

ТОВЬЁОГ

1. ХҮН АМ, ӨРХ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	5
2. МАЛ ТООЛЛОГО, ХӨДӨӨ АЖ АХУЙ.....	7
3. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, АЖ ҮЙЛДВЭР, БИЗНЕС РЕГИСТРИЙН САН	9
4. ТӨСӨВ САНХҮҮ, БАНК, ОРОН НУТГИЙН ӨМЧ	10
5. НИЙГМИЙН ДААТГАЛ	10
6. ТЭЭВЭР, ХОЛБОО, ГАЗАР	10
7. БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГ.....	11
8. ЭРҮҮЛ МЭНД.....	12
9. ГЭМТ ХЭРЭГ	12

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хүн ам, сумдаар, хүйсээр.....	14
Хүснэгт 2. Хүн ам, насны бүлгээр, сумдаар, 2018, 2019 оноор.....	14
Хүснэгт 3. Хүн ам, багаар, харьцуулсан үзүүлэлтээр.....	15
Хүснэгт 4. Гадаадад оршин суугаа иргэд, сумдаар	15
Хүснэгт 5. Өрх, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр	15
Хүснэгт 6. Өрх, багаар, харьцуулсан үзүүлэлтээр	16
Хүснэгт 7. Ажиллах хүч, хүйсээр	16
Хүснэгт 8. Халамж үйлчилгээ, харьцуулсан үзүүлэлтээр.....	17
Хүснэгт 9. Ердийн хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр	17
Хүснэгт 10.Ердийн хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр	17
Хүснэгт 11. Ердийн хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр	18
Хүснэгт 12. Ердийн хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр	18
Хүснэгт 13. Ердийн хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр	18
Хүснэгт 14.Ердийн хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр	18
Хүснэгт 15.Шилжилт хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр	19
Хүснэгт 16. Шилжилт хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр.....	19
Хүснэгт 17.Нийгмийн зарим үзүүлэлтүүд, бүтэн өнчин хүүхэд, сум, багаар.....	19
Хүснэгт 18. Нийгмийн зарим үзүүлэлтүүд, хагас өнчин хүүхэд, сум, багаар	20
Хүснэгт 19. Нийгмийн зарим үзүүлэлтүүд, өрх толгойлсон эцэг, эх, сум, багаар.....	20
Хүснэгт 20. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, сум, багаар	21
Хүснэгт 21. Малтай өрх, сум, багаар, харьцуулсан үзүүлэлтээр.....	21
Хүснэгт 22. Малчин өрх, сум, багаар, харьцуулсан үзүүлэлтээр.....	22
Хүснэгт 23. Мал бүхий өрх, сум, багаар, харьцуулсан үзүүлэлтээр	22
Хүснэгт 24. Малчид, сум, багаар, харьцуулсан үзүүлэлтээр	23
Хүснэгт 25. Эмэгтэй малчид, сум, багаар, харьцуулсан үзүүлэлтээр	23
Хүснэгт 26. Малчид, насны бүлгээр, сум, багаар, харьцуулсан үзүүлэлтээр.....	24
Хүснэгт 27. Малчид, насны бүлгээр, сум, багаар.....	24
Хүснэгт 28. Малын тоо, сумаар, төрлөөр.....	24
Хүснэгт 29. Малын тоо, сум, багаар	25
Хүснэгт 30. Мал төллөлт, сум, багаар, 2015 оны жилийн эцсээр.....	26
Хүснэгт 31. Мал төллөлт, сум, багаар, 2016 оны жилийн эцсээр.....	26
Хүснэгт 32. Мал төллөлт, сум, багаар, 2017 оны жилийн эцсээр.....	27
Хүснэгт 33. Мал төллөлт, сум, багаар, 2018 оны жилийн эцсээр.....	27

Хүснэгт 34. Мал төллөлт, сум, багаар, 2019 оны жилийн эцсээр	28
Хүснэгт 35. Том малын зүй бус хорогдол, сум, багаар.....	28
Хүснэгт 36. Эрлийз, нутгийн шилдэг омгийн мал, сум, багаар.....	29
Хүснэгт 37. Тэжээвэр амьтад, шувуу, сум, багаар.....	29
Хүснэгт 38. Тэжээвэр амьтад, гахай, сум, багаар.....	30
Хүснэгт 39. Газар тариалан, харьцуулсан үзүүлэлтээр	30
Хүснэгт 40. Газар тариалан, харьцуулсан үзүүлэлтээр, Сүмбэр сум	31
Хүснэгт 41. Газар тариалан, харьцуулсан үзүүлэлтээр, Баянтал сум.....	31
Хүснэгт 42. Газар тариалан, харьцуулсан үзүүлэлтээр, Шивээговь сум	32
Хүснэгт 43. Бэлтгэсэн хадлан, тэжээл, харьцуулсан үзүүлэлтээр	32
Хүснэгт 44. Бэлтгэсэн хадлан, тэжээл, харьцуулсан үзүүлэлтээр, Сүмбэр сум	32
Хүснэгт 45. Бэлтгэсэн хадлан, тэжээл, харьцуулсан үзүүлэлтээр, Баянтал сум.....	32
Хүснэгт 46. Бэлтгэсэн хадлан, тэжээл, харьцуулсан үзүүлэлтээр, Шивээговь сум	33
Хүснэгт 47. Дотоодын нийт бүтээгдэхүүн, харьцуулсан үзүүлэлтээр, сая төг	33
Хүснэгт 48. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, харьцуулсан үзүүлэлтээр.....	33
Хүснэгт 49. ШОНУ-н бүтээгдэхүүн, харьцуулсан үзүүлэлтээр.....	33
Хүснэгт 50. Бизнес регистрийн санд бүртгэлтэй ААНБ, 2019 он, салбараар	34
Хүснэгт 51. Төсвийн орлого, харьцуулсан үзүүлэлтээр, сая төгрөг	34
Хүснэгт 52. Төсвийн зарлага, харьцуулсан үзүүлэлтээр, сая төгрөг	34
Хүснэгт 53. Өглөг, авлага, харьцуулсан үзүүлэлтээр, сая төгрөг	35
Хүснэгт 54. Банк, зээл, харьцуулсан үзүүлэлтээр	35
Хүснэгт 55. Бараа, ажил үйлчилгээ, харьцуулсан үзүүлэлтээр.....	35
Хүснэгт 56. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэл	35
Хүснэгт 57. Тээвэр зуучлал, харьцуулсан үзүүлэлтээр.....	36
Хүснэгт 58. Тээврийн хэрэгсэл, харьцуулсан үзүүлэлтээр	36
Хүснэгт 59. Газрын нэгдмэл сан, харьцуулсан үзүүлэлтээр	36
Хүснэгт 60. Газрын нэгдмэл сан, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр	37
Хүснэгт 61. Сургуулийн өмнөх боловсролын бүлэг, хамрагдалт	38
Хүснэгт 62. Сургуулийн өмнөх боловсролд ажиллагсад.....	38
Хүснэгт 63. Ерөнхий боловсролын сургуулийн бүлэг, хамрагдалт	39
Хүснэгт 64. Ерөнхий боловсролын сургуульд ажиллагсад,	39
Хүснэгт 65. Эрүүл мэндийн статистик.....	40
Хүснэгт 66. Гэмт хэргийн статистик.....	40
Хүснэгт 67. Гарсан гэмт хэрэг, сумдаар	41

1. ХҮН АМ, ӨРХ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.1. 2019 оны жилийн эцсийн байдлаар манай аймаг 17445 хүн, үүнээс эрэгтэй 8796, эмэгтэй 8649 хүнтэй боллоо. Өмнөх онтой харьцуулбал хүн ам 44 буюу 0.3 хувиар, үүнээс эрэгтэй 30 буюу 0.3 хувиар өсч, эмэгтэй 74 буюу 0.8 хувиар буурсан үзүүлэлттэй гарлаа. Нийт хүн амын 50.4 хувийг эрэгтэйчүүд, 49.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Нийт хүн амын 6003 буюу 34.4 хувийг 0-14 насны хүүхэд, 10341 буюу 59.2 хувийг 15-59 насны хүмүүс, 1101 буюу 6.3 хувийг 60 ба түүнээс дээш насны хүмүүс эзэлж байна. Насны бүлгээс харахад 70 ба түүнээс дээш настан 398, 80 ба түүнээс дээш настан 121, 90 ба түүнээс дээш настан 17 тоологдлоо. Дээрх үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулбал 70 ба түүнээс дээш настан 1.5 хувиар, 80 ба түүнээс дээш настан 0.8 хувиар, 90 ба түүнээс дээш настан 11.8 хувиар өссөн байна.

Манай аймгийн иргэдээс гадаадад 6 ба түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа 512 иргэн бүртгэгдсэн бөгөөд тэдгээрийн 256 буюу 50.0 хувь нь эрэгтэйчүүд, 256 буюу 50.0 хувь нь эмэгтэйчүүд байна. Өмнөх онтой харьцуулбал гадаадад суугаа иргэд 1.8 дахин өссөн байна.

Тайлант онд 4979 өрх тоологдсон нь өмнөх оноос 409 өрхөөр буюу 7.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Нийт өрхийн 2948 буюу 59.2 хувь нь хотод, 2031 буюу 40.8 хувь нь хөдөөд байршиж байгаа бол нийт өрхийн 1863 буюу 37.4 хувь нь гэрт, 3021 буюу 60.7 хувь нь байшинд, 95 буюу 1.9 хувь нь бусад сууцанд амьдарч байна.

1.2. 2019 онд бүртгэгдсэн 6411 ажиллагчдын 3383 буюу 52.8 хувь нь эрэгтэй, 3028 буюу 47.2 хувь нь эмэгтэй байна. Ажиллагчдыг салбараа нь авч үзвэл:

✓ Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1051
✓ Уул уурхай, олборлолт	805
✓ Боловсруулах	292
✓ Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	186
✓ Усан хангамж, сувагжуулалт, хог хаягдал	41
✓ Барилга	403
✓ Бөөний болон жижиглэн худалдаа	747
✓ Тээвэр ба агуулах	519
✓ Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоол	159
✓ Мэдээлэл холбоо	97
✓ Санхүүгийн болон даатгал	152
✓ Үл хөдлөх хөрөнгө	7
✓ Мэргэжлийн шинжлэх ухаан	97
✓ Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх	101
✓ Төрийн удирдлага ба батлан хамгаалах	660

✓ Боловсрол	630
✓ Хүний эрүүл мэнд, нийгмийн халамж	244
✓ Урлаг, үзвэр	88

Ажиллагчдыг насны бүлгээр авч үзвэл 80 буюу 1.2 хувь нь 15-19 насны, 6294 буюу 98.2 хувь нь 20-64 насны, 37 буюу 0.6 хувь нь тэтгэврийн 65-аас дээш насны хүмүүс байна. Өмнөх онтой харьцуулбал ажиллагчдын тоо 585 буюу 10.0 хувиар өссөн байна.

Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн, ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 2019 оны 12 сард 215 байгаагийн 120 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 75 буюу 53.6 хувиар өссөн байна.

Тайлант онд Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газраас давхардсан тоогоор 7239 хүнд 2038.7 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, халамж үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад үйлчилгээ авсан иргэдийн тоо 228 буюу 3.1 хувиар буурч, олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийн хэмжээ 65.4 сая төгрөг буюу 103.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

1.3. 2019 оны жилийн эцсийн байдлаар аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр аймгийн хэмжээнд 422 эхээс 427 хүүхэд мэндэлсний 212 нь хүү, 215 нь охин байлаа. Нийт 76 хүн нас барсан байна. Бүртгүүлсэн гэр бүл 73, цуцалсан гэр бүл 23, үрчлэгдсэн хүүхэд 9 бүртгэгдлээ. Өмнөх онтой харьцуулахад төрөлт 46 буюу 9.8 хувиар, төрсөн хүүхэд 42 буюу 8.9 хувиар, бүртгүүлсэн гэр бүл 13 буюу 15.1 хувиар, нас баралт 12 буюу 13.6 хувиар тус тус буурч, үрчлэгдсэн хүүхэд өмнөх оны мөн үеийн түвшинд, цуцалсан гэр бүл 6 буюу 35.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Шилжин ирсэн хүн 430 болж нь өмнөх оны мөн үеэс 138 хүн буюу 24.3 хувиар, шилжин явсан хүн 456 болж өмнөх оны мөн үеэс 71 хүн буюу 13.5 хувиар тус тус буурсан байна.

1.4. Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээгээр аймгийн хэмжээнд бүтэн өнчин хүүхэд 20, үүнээс эмэгтэй 10, хагас өнчин хүүхэд 159, үүнээс эмэгтэй 73 байгаа нь өмнөх оны мөн үеэс бүтэн өнчин хүүхэд 1 буюу 5.3 хувиар нэмэгдэж, хагас өнчин хүүхэд 21 буюу 11.7 хувиар буурсан байна.

Өрх толгойлсон эцэг, эх 602 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 76 буюу 21.6 хувиар буурсан байна.

Ганц бие өндөр настан 301 байгаа нь өмнөх оны мөн үеэс 1 буюу 0.3 хувиар, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 742 байгаа нь өмнөх оны мөн үеэс 13 буюу 1.8 хувиар тус тус өсчээ.

2. МАЛ ТООЛЛОГО, ХӨДӨӨ АЖ АХУЙ

2.1. 2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр аймгийн хэмжээнд 1022 малтай өрх тоологдсоноос 699 малчин өрх, 323 малтай өрх тоологдлоо. Малчин өрхөд 2347 хүн амьдарч байгаагаас 1097 малчин, үүнээс 481 нь эмэгтэй малчид байна.

Нийт малчдыг насны бүлгээр нь авч үзвэл:

15-34 нас - 258 малчин буюу 23.5 хувь

35-59 нас - 680 малчин буюу 62.0 хувь

60 аас дээш нас - 159 малчин буюу 14.5 хувийг эзэлж байна.

Өмнөх онтой харьцуулбал малтай өрх 11 буюу 1.0 хувиар өсч, малчин өрх 4 буюу 0.6 хувиар буурсан, мал бүхий өрх 15 буюу 4.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Малчдын тоог өмнөх онтой харьцуулбал 18 буюу 1.7 хувиар үүнээс эмэгтэй малчид 6 буюу 1.3 хувиар буурлаа.

Тайлант онд манай аймагт нэг мянгаас дээш толгой мал тоолуулсан 114 малтай иргэн бүртгэгдсэнээс 112 нь малчин байгаа нь өмнөх оны мөн үеэс 11 буюу 10.9 хувиар нэмэгдлээ. Үүнд:

Сүмбэр сумын мянгат малчин 73

Баянтал сумын мянгат малчин 24

Шивээговь сумын мянгат малчин 15

Хамгийн олон малтай малчин Ц.Нэргүй /Шивээговь сум, 2 дугаар баг/,

Хамгийн олон адуутай малчин Л.Батнасан /Баянтал сум, 2 дугаар баг/,

Хамгийн олон үхэртэй малчин Б.Мянганбаяр /Баянтал сум, 1 дүгээр баг/,

Хамгийн олон тэмээтэй малчин Б.Төмөрмөнх /Шивээговь сум, 2 дугаар баг/,

Хамгийн олон хоньтой малчин А.Замзаах /Баянтал сум, 2 дугаар баг/,

Хамгийн олон ямаатай малчин З.Олонбаатар /Сүмбэр сум, 5 дугаар баг/

	Малтай өрхийн малын бүлэглэлт	Малчин өрхийн малын бүлэглэлт
10 хүртэл толгой малтай	16	2
11-30 толгой малтай	58	13
31-50 толгой малтай	50	16
51-100 толгой малтай	92	40
101-200 толгой малтай	165	81
201-500 толгой малтай	313	235
501-999 толгой малтай	214	200
1000-1499 толгой малтай	81	79
1500-2000 толгой малтай	19	19
2001 түүнээс дээш толгой малтай	14	14

2.2. 2019 оны жилийн эцсээр манай аймаг 452.0 мянган толгой малтай болсон нь өмнөх оны мөн үеэс 24.5 мянган толгой буюу 5.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс: адуу 22.7 мянган толгой, үхэр 14.5 мянган толгой, тэмээ 0.9 мянган толгой, хонь 219.5 мянган толгой, ямаа 194.2 мянган толгой тус тус тоологджээ. Аймгийн хэмжээнд төллөвөл зохих эх малын 84.3 хувь буюу 171.5 мянган толгой мал төллөж, гарсан төл 172.0 мянга, үүнээс 5.4 мянган толгой төл хорогдож, 166.9 мянган толгой төл бойжиж, төл бойжилт 91.5 хувьтай гарлаа.

2018 онд 33.9 мянган толгой төл хорогдсон бол 2019 онд 5.4 мянган толгой төл хорогдож өмнөх оны мөн үеэс 28.5 мянга буюу 662 дахин буурсан байна. Жилийн эцсийн байдлаар 5.7 мянган толгой том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеэс 33.9 мянга буюу 6.9 дахин буурсан байна.

2.3. Эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн мал 14.4 мянга, үүнээс “Сүмбэр” хонь 1.7 мянган толгой тоологдлоо. Өмнөх онтой харьцуулбал эрлийз, цэвэр үүлдрийн мал 3.6 хувиар, “Сүмбэр” хонь 41.7 хувиар тус тус өссөн байна.

Нийт малд эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн мал 3.2 хувийг эзэлж байгаа бол эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн адуу 123 тоологдсон нь нийт адууны 0.5 хувийг, эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн үхэр 261 тоологдсон нь нийт үхрийн 1.8 хувийг, эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн тэмээ 24 тоологдсон нь нийт тэмээний 2.4 хувийг, эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн хонь 7978 тоологдсон нь нийт хонины 3.6 хувийг, эрлийз, цэвэр үүлдэр, сайжруулсан омгийн ямаа 6069 тоологдсон нь нийт ямааны 3.1 хувийг тус тус эзэлж байна.

2.4. Хүн ам, мал, хөдөө аж ахуйн тэжээвэр амьтдын 2019 оны тооллогоор аймгийн дүнгээр гахай, шувуу 493 тоологдсон нь өмнөх оны мөн үеэс 55.5 хувиар өсчээ.

Нийт 112 гахай, үүнээс:

Хээлтэгч	22	
Хээлтүүлэгч	7	
Бусад		83

Нийт 381 шувуу, үүнээс:

Үндсэн эх	327	
Хээлтүүлэгч	54	

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гахай 151 буюу 57.4 хувиар буурч, шувуу 327 буюу 7.1 дахин өссөн байна.

2.5 2019 онд 49.7 га талбайд тариалалт хийснээс төмс 17.9 га-д, хүнсний ногоо 18.8 га-д, тэжээлийн ургамал 13.0 га-д тариалсан байна. Өмнөх онтой харьцуулбал нийт тариалсан талбай 9.5 га буюу 23.6 хувиар өссөн ба төмсний талбай 2.7 га буюу 17.8 хувиар,

хүнсний ногооны талбай 5.8 га буюу 44.6 хувиар, тэжээлийн ургамлын талбай 1 га буюу 8.3 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Ургац хураалтын эцсийн мэдээгээр аймгийн хэмжээнд 326.5 тонн төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал хурааснаас 128.5 тонн төмс, 145.4 тонн хүнсний ногоо, 52.6 тонн тэжээлийн ургамал хурааж авсан нь өмнөх оны мөн үеэс хураасан ургац 56.4 тонноор буюу 20.9 хувиар өсч, үүнээс төмс 31.8 тонн буюу 32.9 хувиар, хүнсний ногоо 14.7 тонн буюу 11.2 хувиар, тэжээлийн ургамал 9.9 тонн буюу 23.2 хувиар өссөн байна.

2019 онд 2125.4 тонн өвс, 1.01 тонн дарш, 507.7 тонн хужир шүү бэлтгэж авсныг өмнөх онтой харьцуулбал бэлтгэсэн өвс 51.6 хувиар, хужир шүү 14.8 хувиар, дарш бэлтгэлт 66.3 хувиар буурсан байна.

3. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, АЖ ҮЙЛДВЭР, БИЗНЕС РЕГИСТРИЙН САН

3.1 Манай аймаг 2019 онд зах зээлийн үнээр 97.6 тэр бум төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь Монгол улсын нийт дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 0.3 хувийг эзэлж байна. 2018 онтой харьцуулбал аймгийн нийт бүтээгдэхүүн 8.5 тэр бум буюу 9.5 хувиар өссөн байна.

Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2019 онд 5.6 сая төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс 0.5 сая төгрөг буюу 9.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

3.2 2019 онд 48.6 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 58.1 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна. Өмнөх онтой харьцуулбал бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 0.2 хувиар, бүтээгдэхүүн борлуулалт 9.3 хувиар тус тус өссөн байна.

“Шивээ-Овоо” ХК нь тайлант онд 45.0 тэр бум төгрөгийн нүүрс үйлдвэрлэж, 55.6 тэр бум төгрөгийн борлуулалт хийсэн байна. Эдгээр үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулбал бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 3.6 хувиар буурч, бүтээгдэхүүн борлуулалт 2.5 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа. Тус компани нь аймгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 93.2 хувийг, нийт борлуулалтын 95.0 хувийг гүйцэтгэж байна.

3.3 2019 онд бизнес регистрийн санд 492 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдсэн байна. Эдгээрийн 384 буюу 78.0 хувь нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа, 50 буюу 10.2 хувь нь үйл ажиллагаагаа эхлээгүй, 23 буюу 4.7 хувь нь үйл ажиллагаагаа түр зогсоосон, 35 буюу 7.1 хувь нь үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон байна.

4. ТӨСӨВ САНХҮҮ, БАНК, ОРОН НУТГИЙН ӨМЧ

4.1 2019 оны байдлаар орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 15456.6 сая төгрөг, гүйцэтгэл 16528.1 сая төгрөг болж орлогын төлөвлөгөө 106.9 хувийн биелэлттэй байна. Төсвийн орлогыг задаргаагаар нь авч үзвэл урсгал орлого 19.7 хувиар даван биелсэн үзүүлэлт гарлаа.

Төсвийн зарлага 15437.6 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 16528.1 сая төгрөг буюу 107.1 хувийн гүйцэтгэлтэй гарлаа. Нийт зардлыг задаргаагаар нь авч үзвэл урсгал зардал 9.7 хувийн хэтрэлтэй гарсан байна.

Төсөвт байгууллагын өглөг, авлагын мэдээгээр өглөгийн үлдэгдэл 255.5 сая төгрөг, авлагын үлдэгдэл 51.5 сая төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс өглөг 3.8 дахин, авлага 1.8 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

4.2. Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулж буй банкуудын салбарын эдийн засгийн үзүүлэлтийг 2019 оны эцсийн байдлаар танилцуулбал цахим банкны үйлчилгээ хэрэглэгчид давхардсан тоогоор 21.0 мянга болж, 69 аж ахуйн нэгжид 1423.0 сая төгрөгийн зээл олгосон бол 8929 иргэдэд 33546.6 сая төгрөгийн зээлийг олгожээ.

4.3. Орон нутгийн өмчийн газрын мэдээгээр манай аймаг 2019 онд 58 бараа, үйлчилгээг 20036.7 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, төлөвлөгөөний дагуу 58 тендер зарлагдаж, 19288.5 сая төгрөгийн бараа, үйлчилгээ гэрээлэгдсэн байна. Өмнөх онтой харьцуулбал төлөвлөгдсөн бараа, үйлчилгээ болон зарлагдсан тендер 4.1 дахин, төлөвлөгдсөн болон гэрээлэгдсэн төсөв 13.7 дахин өссөн байна.

5. НИЙГМИЙН ДААТГАЛ

5.1 Нийгмийн даатгалын сангийн орлого 2019 оны 12 дугаар сарын байдлаар 13430.9 сая төгрөг, зарлага 12470.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс орлого 2495.3 сая төгрөг буюу 22.8 хувиар, зарлага 1606.1 сая төгрөг буюу 14.8 хувиар тус тус өссөн байна.

6. ТЭЭВЭР, ХОЛБОО, ГАЗАР

6.1 Авто тээврийн үндэсний төвийн Говьсүмбэр аймаг дахь салбарын мэдээгээр тайлант онд 7.0 мянган зорчигч тээвэрлэж, зорчигч эргэлт 1481 мян.хүн км болж, 97.8 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

2019 оны байдлаар 4339 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 313 буюу 7.8 хувиар өссөн байна. Тээврийн хэрэгслийг төрлөөр нь авч үзвэл 2018 оноос автобус 45 буюу 160.7 хувиар, ачааны машин 117 буюу 12.1 хувиар, суудлын машин 103 буюу 4.2 хувиар, механизм 3 буюу 9.4 хувиар, чиргүүл 28 буюу 29.5 хувиар, мотоцикл 24 буюу 7.8

хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байгаа бол тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл 7 буюу 5.8 хувиар буурсан байна.

6.2 Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын мэдээгээр манай аймгийн нийт газар нутгийн хэмжээ 554.2 мян.га байдаг бөгөөд нийт талбайн:

376819 га буюу 68.0 хувийг Сүмбэр сум

91606 га буюу 16.5 хувийг Баянтал сум

85755 га буюу 15.5 хувийг Шивээговь сум эзэлж байна.

2019 онд нийт газрын:

481124.8 га буюу 86.8 хувийг - Хөдөө аж ахуйн газар

6662.8 га буюу 1.2 хувийг - Хот, тосгон, суурин газар

5192.5 га буюу 0.9 хувийг - Зам шугам сүлжээний газар

1538.0 га буюу 0.3 хувийг - Усны сан бүхий газар

59661.9 га буюу 10.8 хувийг -Улсын тусгай хэрэгцээний

газар тус тус эзэлж байна. Эдгээр газрыг өмнөх онтой харьцуулбал зам шугам сүлжээний газар 0.9 хувиар нэмэгдэж, хот, тосгон, суурин газар 0.3 хувиар буурч байна.

Тайлант жилд нийт газрын 6.7 хувьд хохирол учирсан байна. Газарт учирсан хохирлыг ангилж үзвэл 99.8 хувь нь бэлчээр ба бусад суурин газарт, 0.1 хувь нь хот тосгон бусад суурин газарт, 0.06 хувь нь ухаж эвдэрсэн газарт учирсан байна.

2019 онд нийт газар нутгийн 5.4 хувь буюу 30027.8 га талбайд газар хамгаалах арга хэмжээ авсан нь өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар буурсан байна.

7. БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГ

7.1 2019-2020 оны хичээлийн жилийн байдлаар аймгийн хэмжээнд төрийн өмчийн 6, хувийн өмчийн 4 нийт 10 цэцэрлэгийн 54 бүлэгт 1725 хүүхэд байгаагаас эмэгтэй 848 хүүхэд хамрагдан хүмүүжиж байна. Цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдийн 205 буюу 11.9 хувь нь малчдын хүүхэд байна. Цэцэрлэгийн бүлгийг тоогоор нь авч үзвэл бага бүлэг 16, дунд бүлэг 9, ахлах бүлэг 10, бэлтгэл бүлэг 11, холимог бүлэг 1, ээлжийн бүлэг 1, нүүдлийн бүлэг 6 байна. Өмнөх онтой харьцуулбал цэцэрлэгт хамрагдсан хүүхэд 0.2 хувиар буурсан хэдий ч эмэгтэй хүүхэд 0.9 хувиар, бүлгийн тоо 1.9 хувиар, малчдын хүүхэд 1.5 хувиар тус тус өссөн байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 175 ажиллагсад байгааг өмнөх онтой харьцуулбал 1.2 хувиар нэмэгдсэн байна.

7.2 2019-2020 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 5 сургуулийн 136 бүлэгт 3797 сурагч суралцаж байгаагаас I-V ангийн 65 бүлэгт 2021 сурагч, VI-IX ангийн 46 бүлэгт

1213, X-XII ангийн 25 бүлэгт 563 сурагч суралцаж байна. Дотуур байранд 142 сурагч амьдарч байна. Өмнөх онтой харьцуулбал бүлгийн тоо 2.4 хувиар, суралцагсад 6.2 хувиар, дотуур байранд амьдарч буй сурагч 7.6 хувиар тус тус өссөн байна.

2019-2020 оны хичээлийн жилд 479 хүүхэд 1-р ангид элсэн орсон нь өмнөх хичээлийн жилээс 10.6 хувиар өсчээ.

Ерөнхий боловсролын сургуульд 281 ажиллагсад байгааг өмнөх онтой харьцуулбал 0.7 хувиар өссөн байна. 185 үндсэн багш ажиллаж байгаа ба нэг багшид ногдох суралцагчийн тоо 20.5 байгаа нь өмнөх оны мөн үеэс 2 пунктээр өссөн байна. Үндсэн багш болон эмч нарын тоо нэмэгдэж, сургалтын менежер, нийгмийн ажилтан болон бусад ажиллагсдын тоо буурсан үзүүлэлт гарлаа.

8. ЭРҮҮЛ МЭНД

8.1 Эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 онд 427 эх амаржиж, 2018 онтой харьцуулахад 44 буюу 9.3 хувиар буурсан байна. Амьд төрсөн хүүхэд 429 үүнээс 218 нь хүү, 211 нь охин байна. Өмнөх онтой харьцуулбал амьд төрсөн хүүхэд 41 буюу 8.7 хувиар буурчээ. 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 5, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл бүртгэгдээгүй байна.

Тайлант онд 97.1 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оноос 11.7 хувиар, 4.9 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оноос 6.0 хувиар тус тус буурсан байна. Халдварт өвчнөөр өвчлөгсөд 166 бүртгэгдсэн нь өмнөх оноос 96 тохиолдлоор буурчээ.

9. ГЭМТ ХЭРЭГ

9.1 Тайлант онд аймгийн хэмжээнд 154 гэмт хэрэг бүртгэгдсэн ба үйлдэгдсэн гэмт хэргийн 62 буюу 40.2 хувь нь хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг байлаа. Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 12.5 хувиар буурсан байна. Гэмт хэрэгт холбогдогсод 103, үүний 46 буюу 44.7 хувь нь ажилгүй иргэдийн үйлдсэн гэмт хэрэг байна. Гэмт хэрэгт холбогдогсдыг өмнөх онтой харьцуулахад 16.9 хувиар буурсан байна.

Давхардсан тоогоор 889 иргэнийг эрүүлжүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 23.5 хувиар өссөн байна.

Гэмт хэрэг илрүүлэлт жилийн эцсийн байдлаар 58.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.4 пунктээр буурсан байна. Гэмт хэргээс учирсан хохирол 405.1 сая төгрөг, нөхөн төлүүлсэн хохирол 121.6 сая төгрөгт хүрсэн байна.

ХАВСРАЛТ

Хүснэгт 1. Хүн ам, сумдаар, хүйсээр

Сумд		2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	$\frac{2019}{2018}$ %
	Нийт хүн ам	1153	1204	1240	1201	1129	94.0
Баянтал	Эрэгтэй	585	606	630	616	576	93.5
	Эмэгтэй	568	598	610	585	553	94.5
	Нийт хүн ам	11901	12352	12710	12773	12704	99.5
Сүмбэр	Эрэгтэй	5974	6125	6307	6335	6358	100.4
	Эмэгтэй	5927	6227	6403	6438	6346	98.6
	Нийт хүн ам	3254	3378	3449	3515	3612	102.8
Шивээговь	Эрэгтэй	1687	1745	1786	1815	1862	102.6
	Эмэгтэй	1567	1633	1663	1700	1750	102.9
	Нийт хүн ам	16308	16934	17399	17489	17445	99.7
Бүгд	Эрэгтэй	8246	8476	8723	8766	8796	100.3
	Эмэгтэй	8062	8458	8676	8723	8649	99.2

Хүснэгт 2. Хүн ам, насны бүлгээр, сумдаар, 2018, 2019 оноор

Насны бүлэг	Аймгийн дүн			Баянтал			Сүмбэр			Шивээговь		
	2018 он	2019 он	$\frac{2019}{2018}$ %	2018 он	2019 он	$\frac{2019}{2018}$ %	2018 он	2019 он	$\frac{2019}{2018}$ %	2018 он	2019 он	$\frac{2019}{2018}$ %
0-4	2321	2226	95.9	152	143	94.1	1690	1621	95.9	479	462	96.5
5-9	2114	2183	103.3	143	142	99.3	1508	1559	103.4	463	482	104.1
10-14	1470	1594	108.4	99	98	99.0	1090	1165	106.9	281	331	117.8
15-19	1268	1186	93.5	83	76	91.6	947	871	92.0	238	239	100.4
20-24	1342	1296	96.6	104	87	83.7	1002	971	96.9	236	238	100.8
25-29	1535	1448	94.3	97	86	88.7	1111	1036	93.2	327	326	99.7
30-34	1508	1512	100.3	90	80	88.9	1063	1082	101.8	355	350	98.6
35-39	1234	1229	99.6	90	82	91.1	883	875	99.1	261	272	104.2
40-44	1105	1108	100.3	84	75	89.3	808	809	100.1	213	224	105.2
45-49	1019	1002	98.3	70	73	104.3	752	741	98.5	197	188	95.4
50-54	850	850	100.0	58	57	98.3	637	634	99.5	155	159	102.6
55-59	676	710	105.0	52	43	82.7	492	524	106.5	132	143	108.3
60-64	429	449	104.7	44	47	106.8	311	320	102.9	74	82	110.8
65-69	226	254	112.4	13	20	153.8	169	185	109.5	44	49	111.4
70-74	158	159	100.6	11	11	100.0	117	119	101.7	30	29	96.7
75-79	114	118	103.5	5	3	60.0	90	90	100.0	19	25	131.6
80-84	80	77	96.3	5	4	80.0	66	64	97.0	9	9	100.0
85-89	21	27	128.6	1	1	100.0	19	22	115.8	1	4	400.0
90-94	15	11	73.3	0	1	*	14	10	71.4	1	0	*
95-99	4	6	150.0	0	0	*	4	6	150.0	0	0	*
Нийт	17489	17445	99.7	1201	1129	94.0	12773	12704	99.5	3515	3612	102.8

Хүснэгт 3. Хүн ам, багаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сум, баг	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	$\frac{2019}{2018}$ %	
Баянтал	Нийт хүн ам	1153	1204	1240	1201	1129	94.0
	I баг	752	782	790	756	722	95.5
	II баг	401	422	450	445	407	91.5
Сүмбэр	Нийт хүн ам	11901	12352	12710	12773	12704	99.5
	I баг	2786	2758	2798	2736	2918	106.7
	II баг	3170	3227	3315	3352	3300	98.4
	III баг	3880	4156	4321	4359	4209	96.6
	IV баг	753	768	774	821	817	99.5
	V баг	690	731	744	753	744	98.8
Шивээговь	VI баг	622	712	758	752	716	95.2
	Нийт хүн ам	3254	3378	3449	3515	3612	102.8
	I баг	2080	2244	2299	2365	2546	107.7
Бүгд	II баг	1174	1134	1150	1150	1066	92.7
	Нийт хүн ам	16308	16934	17399	17489	17445	99.7

Хүснэгт 4. Гадаадад оршин суугаа иргэд, сумдаар

Сумд	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2019/2018
Баянтал	3	16	5	6	19	316.7
Сүмбэр	122	123	141	225	408	181.3
Шивээговь	14	17	40	59	85	144.1
Бүгд	139	156	186	290	512	176.6

Хүснэгт 5. Өрх, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	$\frac{2019}{2018}$ %
Баянтал	361	387	418	410	338	82.4
Сүмбэр	3605	3754	3878	3899	3634	93.2
Шивээговь	1021	1048	1068	1079	1007	93.3
Бүгд	4987	5189	5364	5388	4979	92.4

Хүснэгт 6. Өрх, багаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сум, баг		2015 он	2016 он	2017 он	2019 он	2019 он	2019/2018 %
	Нийт өрх	361	387	418	410	338	82.4
Баянтал	I баг	233	242	256	242	197	81.4
	II баг	128	145	162	168	141	83.9
	Нийт өрх	3605	3754	3878	3899	3634	93.2
	I баг	791	799	805	792	759	95.8
	II баг	1002	1022	1059	1059	1003	94.7
Сүмбэр	III баг	1153	1227	1285	1316	1186	90.1
	IV баг	245	247	250	260	243	93.5
	V баг	218	233	233	232	225	97.0
	VI баг	196	226	246	240	218	90.8
	Нийт өрх	1021	1048	1068	1079	1007	93.3
Шивээговь	I баг	638	679	693	702	687	97.9
	II баг	383	369	375	377	320	84.9
Бүгд	Нийт өрх	4987	5189	5364	5388	4979	92.4

Хүснэгт 7. Ажиллах хүч, хүйсээр

Сумд	2015 он	2016 он	2017 он	2019 он	2019 он	2019/2018
Бүгд	6318	6239	7711	7468	8058	107.9
Эрэгтэй	3222	3223	4028	3850	4222	109.7
Эмэгтэй	3096	3016	3683	3618	3836	106.0

Хүснэгт 8. Халамж үйлчилгээ, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2015 он		2016 он		2017 он		2018 он		2019 он		2019 / 2018 %	
	Хүний тоо	Олгосон тэтгэвэр, тэтгэмж, сая төгрөг	Хүний тоо	Олгосон тэтгэвэр, тэтгэмж, сая төгрөг	Хүний тоо	Олгосон тэтгэвэр, тэтгэмж, сая төгрөг	Хүний тоо	Олгосон тэтгэвэр, тэтгэмж, сая төгрөг	Хүний тоо	Олгосон тэтгэвэр, тэтгэмж, сая төгрөг	Хүний тоо	Олгосон тэтгэвэр, тэтгэмж, сая төгрөг
Нийгмийн халам- жийн сангийн дүн	4508	1225.2	4724	1259.7	5634	1378.2	7467	1973.2	7239	2038.7	96.9	103.3
Нийгмийн халам- жийн тэтгэвэр, тэтгэмж	1484	784.4	1526	814.5	1317	754	2314	1200.1	2264	1246.8	97.8	103.9
Нийгмийн халам- жийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	3024	440.8	3198	445.2	4317	624.2	5153	773.1	4975	791.9	96.5	102.4

Хүснэгт 9. Ердийн хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Амаржсан эх					
	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2019 / 2018 %
Баянтал	42	28	24	34	23	67.6
Сүмбэр	322	337	285	353	344	97.5
Шивээговь	71	94	85	81	55	67.9
Дүн	435	459	394	468	422	90.2

Хүснэгт 10. Ердийн хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Төрсөн хүүхэд					
	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2019 / 2018 %
Баянтал	42	28	24	34	23	67.6
Сүмбэр	328	341	291	354	347	98.0
Шивээговь	71	96	85	81	57	70.4
Дүн	441	465	400	469	427	91.0

Хүснэгт 11. *Ердийн хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр*

Сумд	Үрчлэгдсэн хүүхэд					
	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	$\frac{2019}{2018}$ %
Баянтал	1	1	1	1	1	100.0
Сүмбэр	5	5	5	5	8	160.0
Шивээговь	1	1	1	4	0	0.0
Дүн	7	7	7	9	9	100.0

Хүснэгт 12. *Ердийн хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр*

Сумд	Бүртгүүлсэн гэр бүл					
	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	$\frac{2019}{2018}$ %
Баянтал	3	2	6	3	2	66.7
Сүмбэр	64	56	50	58	59	101.7
Шивээговь	11	23	16	25	12	48.0
Дүн	78	81	72	86	73	84.9

Хүснэгт 13. *Ердийн хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр*

Сумд	Цуцалсан гэр бүл					
	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	$\frac{2019}{2018}$ %
Баянтал	0	1	2	0	0	*
Сүмбэр	21	15	25	9	23	255.6
Шивээговь	3	4	7	8	0	*
Дүн	24	20	34	17	23	135.3

Хүснэгт 14. *Ердийн хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр*

Сумд	Нас баралт					
	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	$\frac{2019}{2018}$ %
Баянтал	5	7	3	6	6	100.0
Сүмбэр	71	84	82	66	61	92.4
Шивээговь	14	24	15	16	9	56.3
Дүн	90	115	100	88	76	86.4

Хүснэгт 15. Шилжилт хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Шилжиж ирсэн					
	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	$\frac{2019}{2018}\%$
Баянтал	110	79	72	43	13	30.2
Сүмбэр	557	540	447	372	307	82.5
Шивээговь	132	126	122	153	110	71.9
Дүн	799	745	641	568	430	75.7

Хүснэгт 16. Шилжилт хөдөлгөөн, сумдаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сумд	Шилжиж явсан					
	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	$\frac{2019}{2018}\%$
Баянтал	49	56	62	42	27	64.3
Сүмбэр	484	530	322	394	332	84.3
Шивээговь	144	101	104	91	97	106.6
Дүн	677	687	488	527	456	86.5

Хүснэгт 17. Нийгмийн зарим үзүүлэлтүүд, бүтэн өнчин хүүхэд, сум, багаар

Сум, баг	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	$\frac{2019}{2018}\%$
Нийт	1	0	0	0	0	0
Баянтал						
I баг	0	0	0	0	0	0
II баг	1	0	0	0	0	0
Нийт	21	21	18	16	17	106.3
Сүмбэр						
I баг	3	3	5	5	6	120.0
II баг	9	9	7	5	6	120.0
III баг	8	8	5	5	4	80.0
IV баг	1	1	1	1	1	100.0
V баг	0	0	0	0	0	0
VI баг	0	0	0	0	0	0
Нийт	1	3	3	3	3	100.0
Шивээговь						
I баг	0	1	0	1	2	200.0
II баг	1	2	3	2	1	50.0
Бүгд	23	24	21	19	20	105.3

Хүснэгт 18. Нийгмийн зарим үзүүлэлтүүд, хагас өнчин хүүхэд, сум, багаар

Сум, баг	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	$\frac{2019}{2018}$ %
Нийт	3	10	13	12	14	116.7
Баянтал						
I баг	3	5	8	9	9	100.0
II баг	0	5	5	3	5	166.7
Нийт	150	143	145	126	114	90.5
Сүмбэр						
I баг	47	41	40	34	36	105.9
II баг	57	57	58	44	31	70.5
III баг	30	31	25	22	22	100.0
IV баг	5	4	5	5	5	100.0
V баг	9	10	10	12	12	100.0
VI баг	2	0	7	9	8	88.9
Нийт	24	32	26	42	31	73.8
Шивээговь						
I баг	16	20	13	19	9	47.4
II баг	8	12	13	23	22	95.7
Бүгд	177	185	184	180	159	88.3

Хүснэгт 19. Нийгмийн зарим үзүүлэлтүүд, өрх толгойлсон эцэг, эх, сум, багаар

Сум, баг	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	$\frac{2019}{2018}$ %
Нийт	37	54	33	33	34	103.0
Баянтал						
I баг	27	32	21	21	22	104.8
II баг	10	22	12	12	12	100.0
Нийт	577	592	609	607	487	80.2
Сүмбэр						
I баг	233	264	267	266	163	61.3
II баг	180	163	164	161	149	92.5
III баг	105	114	116	110	104	94.5
IV баг	24	19	11	12	14	116.7
V баг	14	24	24	25	24	96.0
VI баг	21	8	27	33	33	100.0
Нийт	131	133	137	128	81	63.3
Шивээговь						
I баг	49	65	68	63	20	31.7
II баг	82	68	69	65	61	93.8
Бүгд	745	779	779	768	602	78.4

Хүснэгт 20. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, сум, багаар

Сум, баг	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	$\frac{2019}{2018}$ %
Нийт	48	53	55	55	54	98.2
Баянтал						
I баг	30	34	36	31	29	93.5
II баг	18	19	19	24	25	104.2
Нийт	464	466	477	507	531	104.7
I баг	133	116	116	113	117	103.5
II баг	154	159	162	162	162	100.0
Сүмбэр						
III баг	98	111	119	128	147	114.8
IV баг	28	29	31	42	43	102.4
V баг	35	35	30	34	36	105.4
VI баг	16	16	19	28	26	92.9
Нийт	157	164	156	167	157	94.0
Шивээговь						
I баг	78	89	96	103	97	94.2
II баг	79	75	60	64	60	93.8
Бүгд	669	683	688	729	742	101.8

Хүснэгт 21. Малтай өрх, сум, багаар, харьцуулсан үзүүлэлтээр

Сум, баг	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	$\frac{2018}{2019}$ %
Нийт	153	156	146	145	144	99.3
Баянтал						
I баг	88	88	78	78	76	97.4
II баг	65	68	68	67	68	101.4
Нийт	693	753	750	723	723	100.0
I баг	47	50	38	29	25	82.6
II баг	71	72	68	61	54	88.5
Сүмбэр						
III баг	69	73	72	67	79	117.9
IV баг	177	190	189	192	192	100.0
V баг	162	175	176	173	179	103.4
VI баг	167	193	207	201	194	96.5
Нийт	148	145	145	143	155	108.3
Шивээговь						
I баг	20	21	23	25	36	144
II баг	128	124	122	118	119	100.8
Бүгд	994	1054	1041	1011	1022	101.0

Хүснэгт 22. Малчин өрх, сум, багаар, харьцуулсан үзүүлэлтээр

